МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2026 оны 04 сарын 22 өдөр Дугаар А/51 Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх хэсэг, 84 дүгээр зүйлийн 84.4.1 дэх заалт, Компанийн дүрмийн 10.8.11 дэх заалт, Хөдөлмөрийн дотоод журмын 2.1.1 дэх заалт, Захирлын шуурхай хуралдааны 2026 оны 04 дүгээр сарын 21 -ны өдрийн шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Компанийн "Төлөвлөгөө, тайлан боловсруулах, ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам"-ыг 1 дүгээр, Улаанбаатар хотын газруудыг үнэлэх үнэлгээг 2 дугаар, аймаг, дүүргийн газруудыг үнэлэх үнэлгээг 3 дугаар, газрын захирал, ерөнхий инженер, аймаг, дүүргийн газрын дарга нарыг үнэлэх үнэлгээг 4 дүгээр, менежер, ахлах инженерийг үнэлэх үнэлгээг 5 дугаар, ажилтны үнэлгээг 6 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн батлсугай.
2. Журмыг баталсан өдрөөс эхлэн компанийн нийт газар, ажилтнуудад танилцуулах ажлыг зохион байгуулахыг Эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын газар (С.Мөнхзориг), Захиргаа, хүний нөөцийн газар (Б.Бадамхорол) нарт тус тус үүрэг болгосугай.
3. Журмыг шинэчлэн баталсантай холбогдуулан Гүйцэтгэх захирлын 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/16 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гэрээ, хууль, эрх зүйн газар (И.Энхмаа)-т даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ С.АДЪЯАСҮРЭН

УЛААНБААТАР ХОТ
МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ ХХК
9022050763
5081092 СБТ18969

1526050314

Монгол шуудан хязгаарлалтай компанийн Захиргаа, хүний нөөцийн газрын дарга

Монгол шуудан хязгаарлалтай компанийн захиргаа, хүний нөөцийн газрын дарга Б.Мөнхсайхан — гэх этгээдтэй хийгдэх хөдөлмөрийн гэрээний тухай

Монгол шуудан хязгаарлалтай компанийн захиргаа, хүний нөөцийн газрын дарга Б.Мөнхсайхан (цаашдын нэрлэхдээ "Ажилтан") гэх этгээдтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах тухай асуудлыг хэлэлцэн доорх агуулгатай гэрээ хийгдэхийг зөвшөөрсүгэй.

1. Ажилтан нь Монгол шуудан хязгаарлалтай компанийн захиргаа, хүний нөөцийн газрын дарга ажлыг гүйцэтгэнэ. Ажлын цаг нь 09:00-18:00 цаг байна. Ажлын 1 сарын туршилтын хугацаатай.

2. Ажлын хөлс нь сар бүр 1,800,000 төгрөг байна. Ажлын гүйцэтгэлийг жилийн 2 удаа үнэлэх бөгөөд үнэлгээний дүнгээс хамаарч нэмэгдэл олгоно.

3. Ажилтан нь компанийн дотоодын журам, нууцлалтай холбоотой мэдээлэлтэй танилцсан гэдгээ баталгаажуулна. Нууцлалтай холбоотой мэдээлэлтэй танилцах, ашиглах эрхийг зөвхөн ажлын зорилгоор олгоно.

4. Ажилтан нь компанийн дотоодын журмыг зөрчсөн тохиолдолд Монгол шуудан хязгаарлалтай компаниас ажлаас чөлөөлөгдөнө.

Монгол шуудан хязгаарлалтай компанийн захиргаа, хүний нөөцийн газрын дарга Б.Мөнхсайхан

Ажилтан Б.Мөнхсайхан

УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛ ШУУДАН ХЯЗГААРЛАЛТАЙ КОМПАНИ
9022050763
5081092 CST18969

15260602

Гүйцэтгэх захирлын 2026 оны ..04.. дүгээр сарын
..22.. өдрийн ..1/91.. дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

УЛААНБААТАР ХОТ
ХОРООНЫ ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
СҮЛКЭЭ ХХК
9022050763

ТӨЛӨВЛӨГӨӨ, ТАЙЛАН БОЛОВСРУУЛАХ, АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмаар компанийн ажилтан, төвийн газар, аймаг, дүүргийн газар нь үйл ажиллагаагаа сар, улирал, хагас жил, жилээр төлөвлөх, тайлагнах, ажлын гүйцэтгэлийг үнэлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1.2.Энэ журамд төлөвлөгөө, тайлан нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

1.2.1.компанийн газрын үйл ажиллагааны сар, улирал, хагас жил, жилийн төлөвлөгөө, тайлан;

1.2.2. аймаг, дүүргийн газрын сар, улирал, хагас жил, жилийн төлөвлөгөө тайлан;

1.2.3 ажилтны сар, улирал, хагас жил, жилийн төлөвлөгөө, тайлан;

1.3.Энэхүү журамд хэрэглэсэн нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.3.1.“ажлын төлөвлөгөө” гэж Улаанбаатар хот, аймаг, дүүргийн газар, ажилтан нь энэхүү журмын 1.2 дахь хэсэгт заасан хугацаанд чиг үүрэгтэйгээ холбогдуулан хэрэгжүүлэх зорилт, ажлын төлөвлөгөөг;

1.3.2.“ажлын тайлан” гэж энэхүү журмын 1.3.1 дэх заалтад заасан төлөвлөгөөний биелэлтийг;

1.3.3.“зорилтот үр дүн” гэж ажилтны ажлын төлөвлөгөөний биелэлт, төлөвлөсөн хугацаа дуусахад хүрэхээр хүлээгдэж буй үр дүнг;

1.3.4.“шууд удирдлага” гэж албаны дарга, газрын захирал, ерөнхий инженер, аймаг, дүүргийн газрын даргыг;

1.3.5.“Байгууллагын цахим систем” гэж төлөвлөгөө, тайланг хүлээн авч, нэгтгэн боловсруулж, хадгаламжийн нэгж бүрдүүлэх зорилгоор үүсгэсэн дундын систем;

1.3.6.“Улаанбаатар хотын газрыг үнэлсэн үнэлгээ” гэж Гүйцэтгэх захирлын сар бүр төвийн газрууд болон ашиглалтын газруудыг үнэлсэн үнэлгээг;

1.3.7.“Аймаг, дүүргийн газрын үнэлгээ” гэж Санхүүгийн үзүүлэлтэд суурилсан үнэлгээг Бодлого, төлөвлөлтийн газар, Бизнес түншлэл, харилцагчийн удирдлагын газар, Санхүүгийн удирдлагын газар, Технологийн үзүүлэлтэд суурилсан үнэлгээг Үндсэн сүлжээний газар, Эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын газар мөн Захиргаа, хүний нөөцийн газраас өгсөн үнэлгээний нийлбэрийг;

1.4.Төлөвлөгөө боловсруулахад дараах шаардлагууд тавигдана. Үүнд:

-компанийн үйлчилгээг чанартай, хурдан шуурхай, үр дүнтэй хэрэгжүүлэхэд чиглэсэн байх;

-газар хоорондын уялдааг хангасан байх;

-үр дүнд суурилсан, бодитой, биелэгдэхүйц суурь болон зорилтот түвшингээ тодорхойлсон байх;

-хэмжигдэхүйц байх;

-мэдээллийн үнэн зөв, найдвартай байдлыг хангасан байх;

-тоон үзүүлэлт нь чанарын үзүүлэлтээр баталгаажсан байх;
-хууль тогтоомжид нийцсэн байх;

Хоёр. Газрын төлөвлөгөө, тайлан

2.1.Улаанбаатар хот, аймаг, дүүргийн газар нь төлөвлөгөө, тайлангийн нэгтгэлээ Байгууллагын цахим системээр Хүснэгт №1-д заасан хугацаанд илгээснээр Эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын газарт ирүүлсэнд тооцно.

2.2.Аймаг, дүүргийн газар нь дараа сарын 05-ны өдрийн дотор Үндсэн сүлжээний газарт техник ашиглалт, үйлчилгээний тайлангаа илгээнэ.

Хүснэгт №1 Төлөвлөгөө, тайлан ирүүлэх хуваарь

Төрөл / Хугацаа	**Төлөвлөгөө**	**Тайлан**
Сар	Өмнөх сарын 25-ны өдрийн дотор	Дараа сарын 08-ны өдрийн дотор
Улирал	Өмнөх сарын 25-ны өдрийн дотор	Дараа сарын 08-ны өдрийн дотор
Хагас жил	05 дугаар сарын 25-ны өдрийн дотор, 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор	07 дугаар сарын 08-ны өдрийн дотор, 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор
Жил	Өмнөх жилийн 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор	12 дугаар сарын 20-ны өдрийн дотор

2.3.Төлөвлөгөө, тайланг Эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын газар тухай бүр нэгтгэж Гүйцэтгэх захиралд танилцуулна.

2.4.Улаанбаатар хот, аймаг, дүүргийн газар нь дээд шатны байгууллагууд руу илгээх хагас жил болон жилийн төлөвлөгөөг 4 дүгээр, тайланг 5 дугаар хавсралтын дагуу Хүснэгт №1-д заасан хугацаанд Эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын газарт ирүүлнэ.

Гурав. Газрын тайланг үнэлэх, хадгалах

3.1.Улаанбаатар хотын газруудын үнэлгээг энэхүү журмын 2 дугаар хавсралтад заасны дагуу Эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын газар хүлээн авч хянаж, үнэлэн, үнэлгээг нэгтгэж, газрын захирал нь Гүйцэтгэх захиралд хүргэж эцсийн үнэлгээ гарна.

3.2.Аймаг, дүүргийн газрын сарын ажлын гүйцэтгэлийг үнэлэхдээ Санхүүгийн үзүүлэлтэд суурилсан Бодлого, төлөвлөлтийн газар, Бизнес түншлэл, харилцагчийн удирдлагын газар, Санхүүгийн удирдлагын газар, Технологийн үзүүлэлтэд суурилсан Үндсэн сүлжээний газар, Эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын газар мөн Захиргаа, хүний нөөцийн газар нь тогтоосон шалгуур үзүүлэлтээр, журмын 3 дугаар хавсралтад заасны дагуу үнэлнэ.

3.3.Албаны дарга, газрын захирал, ашиглалтын газрын ерөнхий инженер, аймаг, дүүргийн газрын даргыг энэхүү журмын 4 дүгээр хавсралтад заасны дагуу үнэлсэн үнэлгээг Эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын газар хянаж, үнэлгээг нэгтгэж, газрын захирал нь Гүйцэтгэх захиралд хүргэж эцсийн үнэлгээ гарна.

3.4.Газрын захирал, ерөнхий инженерүүд нь ажилтны ажлын гүйцэтгэлийг журмын 5, 6 дугаар хавсралтад заасны дагуу үнэлнэ.

3.5.Эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын газар нь Улаанбаатар хот, аймаг, дүүргийн газрын жилийн ажлын нэгдсэн үнэлгээг гаргаж захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх бөгөөд уг үнэлгээ нь тухайн жилийн шилдэг газар, ажилтныг шалгаруулах үндэслэл болно.

3.6.Тэргүүн байранд үнэлэгдсэн аймаг, дүүргийн газрын ерөнхий инженерийг тухайн жилийн шилдэг ерөнхий инженерээр шалгаруулна.

3.7.Компанийн газрууд нь жилийн төлөвлөгөө, тайлангаа компанийн хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу цахимаар болон цаасан суурьтай хадгаламжийн нэгж болгон архивд хүргүүлнэ.

3.8.Компанийн Цахим үйл ажиллагаа хариуцсан хэсэг нь төлөвлөгөө, тайланг цахим хэлбэрээр архивын хадгаламжийн нэгж болгон хадгална.

Дөрөв. Ажилтны ажлын төлөвлөгөө, тайлан, үр дүнгийн урамшуулал

4.1.Ажилтан хөдөлмөрийн гэрээ болон ажлын байрны тодорхойлолттой уялдуулан сар бүрийн төлөвлөгөөг өмнөх сарын 25-ны өдрийн дотор, тайлангаа дараа сарын 08-ны өдрийн дотор Байгууллагын цахим системд илгээнэ.

4.2.Ажилтан нь тухайн сарын ажлын өдрүүдийн 30 хувиас дээш хугацаанд ажилласан бол ажилласан хоногоор гүйцэтгэлийн хувь тооцож урамшуулалд хамруулж болно.

4.3.Шинээр ажилд орсон ажилтанд үндсэн ажилтнаар ажиллуулах Гүйцэтгэх захирлын болон аймаг, дүүргийн газрын даргын тушаал гарснаас хойш урамшуулал олгоно.

4.4.Ажилтны тухайн жилийн ажлын гүйцэтгэлийг үндэслэн Гүйцэтгэх захирлын болон аймаг, дүүргийн газрын даргын тушаалаар **шагналт цалин** олгож болно.

Тав.Ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлэх

5.1.Ажилтан сарын ажлын гүйцэтгэлээ Байгууллагын цахим системд илгээж менежер, ахлах мэргэжилтэн, ахлах инженер нэгтгэнэ.

5.2.Газрын захирал нь ажилтны ирүүлсэн ажлын тайлантай танилцаж менежер, ахлах мэргэжилтэн, ахлах инженер саналыг харгалзан сар бүр гүйцэтгэлийг нь 6 дугаар хавсралтад заасны дагуу үнэлнэ.

5.3.Ажилтны сарын ажлын үнэлгээг үндэслэн Гүйцэтгэх захирлын болон аймаг, дүүргийн газрын даргын тушаалаар сарын үндсэн цалингийн 50 хүртэлх хувиар тооцож сар бүр урамшуулал олгож болно. (Энэ хэсгийг 2026 оны 05 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөнө.)

5.4.Сар бүрийн урамшууллыг олгохдоо энэхүү журмын Хавсралт 2, Хавсралт 3-т заасны дагуу үнэлсэн үнэлгээг харгалзан Бодлого төлөвлөлтийн газраас тухайн

сарын урамшууллын санг тооцож албаны дарга, газрын захирал, ерөнхий инженер, аймаг, дүүргийн газрын дарга нарт хүргүүлнэ.

5.5. Албаны дарга, газрын захирал, ерөнхий инженер, аймаг, дүүргийн газрын дарга нар тухайн сарын урамшууллыг олгохдоо одоо ажиллаж байгаа нийт ажилчдын 50 хувиас хэтрүүлэхгүйгээр олгоно.

5.6.Газрын захирал нь ажилтны сарын ажлын гүйцэтгэлийг дараах аргачлалын дагуу үнэлнэ.

5.6.1.Ажилтны сарын ажлын үнэлгээ нь өөрийн тайлангийн үнэлгээгээр 30 хүртэлх оноо байна.

5.6.2.Газрын захирал нь 50 хүртэлх оноогоор ажилтнаа үнэлнэ.

5.6.3.Газрын захирал, менежерээс өгсөн үүрэг даалгаврын гүйцэтгэлийг Хүснэгт №2-ын дагуу үнэлэх бөгөөд энэ үнэлгээ нь нийт үнэлгээний 20 хүртэл оноо байна.

Хүснэгт №2. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг үнэлэх аргачлал

Оноо (20 хүртэл)	Биелэлт
18-20 оноо	Бүрэн биелүүлсэн 90-100%-ийн гүйцэтгэлтэй
16-17 оноо	Дийлэнх хэсгийг биелүүлсэн 80-89%-ийн гүйцэтгэлтэй
12-15 оноо	Ихэнх хэсгийг биелүүлсэн 70-79%-ийн гүйцэтгэлтэй
0-11 оноо	Хэсэгчлэн биелүүлсэн 0-69%-ийн гүйцэтгэлтэй

5.7.Ажилтны сарын нэгдсэн үнэлгээ нь:

5.7.1. 90-100 оноо “Маш сайн”

5.7.2. 80-89 оноо “Сайн”

5.7.3. 70-79 оноо “Хангалттай”

5.7.4. 69-өөс доош оноо “Хангалтгүй” гэж тооцогдох бөгөөд тухайн сард урамшуулалт цалин олгохгүй.

5.8.Хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулсан болон сарын тайлангаа ирүүлээгүй ажилтанд тухайн сарын урамшуулалт цалинг олгохгүй.

5.9.Хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллаж байгаа ажилтанд урамшуулалт цалин олгохгүй.

5.10.Ажилтан үндсэн ажлын дагуу, үр нөлөөгөө өгөхүйц байдлаар хувийн зардлаар мэргэжил, мэргэшлээ дээшлүүлсэн, сургалтад амжилттай хамрагдсан бол тайлант сарын урамшуулалт цалинг олгохдоо үр дүнг нь харгалзан үзэж болно.

Зургаа.Бусад

6.1.Ажилтны сарын ажлын тайлан нь иж бүрэн, бодитой, итгэл үнэмшил төрүүлэхүйц, аль болох товч, тодорхой, хэмжигдэхүйц, суурь болон зорилтот түвшинтэй байх гэсэн шаардлагыг хангасан байна.

6.2.Шууд удирдлага ажилтны сарын ажлын тайланг хянаж, үнэлгээ өгөхдөө шаардлагатай тохиолдолд ажилтантай ярилцлага хийн гарын үсэг зурж баталгаажуулж болно.

6.3.Нийтлэг үйлчилгээний ажилтнууд болох Кабельчин, Сувагчин, Сантехникч, ЦТМ сахиул, Үйлчлэгч, Харуул, Жижүүр, Сахиул, Тогооч, Жолооч, болон сумын ажилтнууд нь тайлан, төлөвлөгөө гаргахгүй байж болох бөгөөд шууд удирдлага нь ажлын гүйцэтгэлийг нь энэхүү журмын 5.6, 5.7 дахь хэсэгт заасан аргачлалын дагуу үнэлнэ.

6.4.Ажилтан өөр албан тушаалд шилжсэн, сэлгэн ажилласан бол ажилласан хугацааны гүйцэтгэлийг ажиллаж байсан шууд удирдлага нь дүгнэж, үнэлгээг шилжсэн газрын шууд удирдлагад шилжүүлнэ.

6.5.Байгууллагын цахим системд мэдээллийн аюулгүй байдал, нууцлалыг Эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын газрын мэргэжилтэн хариуцна.

Долоо. Хариуцлага

7.1.Энэхүү журамд заасны дагуу хугацаандаа төлөвлөгөө, тайлангаа удаа дараа ирүүлээгүй газар, ажилтны сарын ажлын тайланг журмын 5 дугаар хавсралтад заасны дагуу үнэлээгүй нь шууд удирдлагад сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болохгүй.

7.2.Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тогтоосон хугацаанд төлөвлөгөө, тайлангаа Байгууллагын цахим системд илгээгүй ажилтанд урамшуулалт цалин олгохгүй.

7.3.Тайланд үнэлгээ өгсөн эрх бүхий албан тушаалтнууд тухайн ажилтны гүйцэтгэлийн үнэлгээг санаатай болон санамсаргүй байдлаар буруу үнэлсэн нь тогтоогдсон бол уг албан тушаалтанд хариуцлага тооцох үндэслэл болно.

7.4.Сарын тайлангийн үнэлгээгээр 3 ба түүнээс дээш удаа 69 онооноос доогуур үнэлгээ авч, хангалтгүй үнэлэгдсэн ажилтан мөн жилийн ажлын үнэлгээгээр сүүлийн 3 байр эзэлсэн газрын захирал, ерөнхий инженер, аймаг, дүүргийн газрын даргад хөдөлмөрийн гэрээ цуцлах хүртэлх хариуцлага тооцох үндэслэл болно.

7.5.Энэхүү журмаар зохицуулаагүй харилцааг Хөдөлмөрийн тухай хууль болон Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу шийдвэрлэнэ.

МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ ХХК

Гүйцэтгэх захирлын 2026 оны 04 дүгээр сарын 22 өдрийн А/51 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

УЛААНБААТАР ХОТ ХОТЫН ГАЗРЫН ХӨГЖЛИЙН СҮЛЖЭЭ ХХК 9022050763

УЛААНБААТАР ХОТЫН ГАЗРУУДЫГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХҮСНЭГТ

Газрын нэр	Төлөвлөгөөт ажлын биелэлт (50 оноо)	Зорилтот гүйцэтгэл (30 оноо)		Гүйцэтгэлийн хугацаа	
		Хувь (0-100)	Түвшин (1-5)	Төлөвлөгөө, тайлан хугацаандаа ирүүлсэн байдал (10 оноо)	Үүрэг даалгавар хугацаандаа биелүүлсэн байдал (10 оноо)
ТУЗ-ын ажлын алба					
Бодлого, төлөвлөлтийн газар					
Бизнес түншлэл, харилцагчийн удирдлагын газар					
Олон улсын бизнес, хамтын ажиллагааны газар					
Үндсэн сүлжээний газар					
Хотын сүлжээний газар					
Захиргаа, хүний нөөцийн газар					
Гэрээ, хууль эрх зүйн газар					
Санхүүгийн удирдлагын газар					
Эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын газар					

ДҮГНЭСЭН: ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ (……)

НЭГТГЭСЭН: ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА, ДОТООД ХЯНАЛТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ (……)

Гүйцэтгэх захирлын 2026 оны .04. дүгээр сарын
.22. өдрийн .A/51. дугаар тушаалын 3 дугаар хавсралт

УЛААНБААТАР ХОТ
ХОТ ТӨЛӨВЛӨЛТ ХӨГЖЛИЙН ГАЗАР СҮЛЖЭЭ ХХК
УБ22050763
5081092 СБТ18969

АЙМАГ, ДҮҮРГИЙН ГАЗРУУДЫГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХҮСНЭГТ

Д/д	Газрын нэр	Захиргаа, хуний нөөцийн газар (10 оноо)	Санхүүгийн удирдлагын газар (15 оноо)	Бодлого төлөвлөлтийн газар (10 оноо)	Бизнес түншлэл, хөрөнгө оруулалтын удирдлагын газар (10 оноо)	Эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын газар (ЭУ, ХАБЭА, ДХ 15 оноо)	Үндсэн сулжээний газар (40 оноо)	Нийт оноо (100 оноо)
1	Архангай аймаг							
2	Баян-Өлгий аймаг							
3	Баянхонгор аймаг							
4	Булган аймаг							
5	Говь-Алтай аймаг							
6	Дархан-уул аймаг							
7	Дорнод аймаг							
8	Дорноговь аймаг							
9	Дундговь аймаг							
10	Завхан аймаг							
11	Орхон аймаг							

12	Өвөрхангай аймаг							
13	Өмнөговь аймаг							
14	Сүхбаатар аймаг							
15	Сэлэнгэ аймаг							
16	Увс аймаг							
17	Хөвсгөл аймаг							
18	Ховд аймаг							
19	Хэнтий аймаг							
20	Төв аймаг							
21	Багануур дүүрэг							

ДҮГНЭСЭН: ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ (……)

НЭГТГЭСЭН: ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА, ДОТООД ХЯНАЛТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ (……)

Гүйцэтгэх захирлын 2026 оны 04 дүгээр сарын 22 өдрийн А/51 дугаар тушаалын 4 дүгээр хавсралт

ГАЗРЫН ЗАХИРАЛ, АШИГЛАЛТЫН ГАЗРЫН ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР БОЛОН АЙМАГ, ДҮҮРГИЙН ГАЗРЫН ДАРГЫГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХҮСНЭГТ

Д/д	Албан тушаал	Сарын үнэлгээ	
		Газрын тайлангийн үнэлгээ (50 оноо)	Гүйцэтгэл захирал (50 оноо)
1.	Төлөөлөн удирдах зөвлөлийн албаны дарга		
2.	Бодлого, төлөвлөлтийн газрын захирал		
3.	Бизнес түншлэл, харилцагчийн удирдлагын газрын захирал		
4.	Олон улсын бизнес, хамтын ажиллагааны газрын захирал		
5.	Захиргаа, хүний нөөцийн газрын захирал		
6.	Гэрээ, хууль эрх зүйн газрын захирал		
7.	Санхүүгийн удирдлагын газрын захирал		
8.	Эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын газрын захирал		
9.	Үндсэн сүлжээний газрын ерөнхий инженер		
10.	Хотын сүлжээний газрын ерөнхий инженер		
11.	Архангай аймгийн газрын дарга		
12.	Баян-Өлгий аймгийн газрын дарга		
13.	Баянхонгор аймгийн газрын дарга		

14.	Булган аймгийн газрын дарга		
15.	Говь-Алтай аймгийн газрын дарга		
16.	Дархан-уул аймгийн газрын дарга		
17.	Дорнод аймгийн газрын дарга		
18.	Дорноговь аймгийн газрын дарга		
19.	Дундговь аймгийн газрын дарга		
20.	Завхан аймгийн газрын дарга		
21.	Орхон аймгийн газрын дарга		
22.	Өвөрхангай аймгийн газрын дарга		
23.	Өмнөговь аймгийн газрын дарга		
24.	Сүхбаатар аймгийн газрын дарга		
25.	Сэлэнгэ аймгийн газрын дарга		
26.	Увс аймгийн газрын дарга		
27.	Хөвсгөл аймгийн газрын дарга		
28.	Ховд аймгийн газрын дарга		
29.	Хэнтий аймгийн газрын дарга		
30.	Төв аймгийн газрын дарга		
31.	Багануур дүүргийн газрын дарга		

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ (……..)

Гүйцэтгэх захирлын 2026 оны 04 дүгээр сарын 22 өдрийн 4/51 дугаар тушаалын 5 дугаар хавсралт

УЛААНБААТАР ХОТ ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН СУДЛАЛЫН ХХК 9022050763 5081092 СБТ18969

..... ГАЗРЫН МЕНЕЖЕРҮҮД, АХЛАХ ИНЖЕНЕРИЙГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХҮСНЭГТ

Д/д	Албан тушаал	Сарын үнэлгээ	
		Газрын тайлангийн үнэлгээ (50 оноо)	Газрын захирал (50 оноо)
1			
2			
3			

ҮНЭЛСЭН:

..... ГАЗРЫН ЗАХИРАЛ (ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР) …… (……)

Гүйцэтгэх захирлын 2026 оны 04 дүгээр сарын 22 өдрийн А/55 дугаар тушаалын 6 дугаар хавсралт

УЛААНБААТАР ХОТ
МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ ГАЗАР ХХК
9022050763
5081092 СБТ18069

АЖИЛТНЫ САРЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХҮСНЭГТ

Хэсгийн нэр:.....

Д/д	Албан тушаалын нэр	Ажилтны нэр	Тайлангийн үнэлгээ		Үүрэг даалгаврын үнэлгээ (20 оноо)	Нийт оноо (100 оноо)
			Өөрийн тайлангийн үнэлгээ (30 оноо)	Газрын захирлын үнэлгээ (50 оноо)		
1						
2						
3						
4						
……						

ҮНЭЛСЭН:

..... ГАЗРЫН ЗАХИРАЛ (ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР) …… (……)

Шалгуур үзүүлэлт 1

УЛААНБААТАР ХОТ
ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ
9022050763
5081092 СБТ18969

БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРААС АЙМАГ, ДҮҮРГИЙН ГАЗРУУДАД ӨГӨХ ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

д/д	Газрын нэр	Орлогын төлөвлөгөө биелүүлсэн байдал	Зардлын төлөвлөгөө биелүүлсэн байдал	Орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн	Зардлын гүйцэтгэл хэмнэсэн байдал	Нийт оноо
	Авбал зохих оноо	2	2	3	3	10
1	Архангай аймаг					
2	Баян-Өлгий аймаг					
3	Баянхонгор аймаг					
4	Булган аймаг					
5	Говь-Алтай аймаг					
6	Дархан-уул аймаг					
7	Дорнод аймаг					
8	Дорноговь аймаг					
9	Дундговь аймаг					
10	Завхан аймаг					
11	Орхон аймаг					
12	Өвөрхангай аймаг					
13	Өмнөговь аймаг					
14	Сүхбаатар аймаг					
15	Сэлэнгэ аймаг					
16	Увс аймаг					
17	Хөвсгөл аймаг					
18	Ховд аймаг					
19	Хэнтий аймаг					
20	Төв аймаг					
21	Баганаур дүүрэг					

ГАЗРЫН ЗАХИРАЛ Ц.ОДХҮҮ

Шалгуур үзүүлэлт 2

БИЗНЕСИЙН ТҮНШЛЭЛ, ХАРИЛЦАГЧИЙН УДИРДЛАГЫН ГАЗРААС АЙМАГ, ДҮҮРГИЙН ГАЗРУУДАД ӨГӨХ ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

УЛААНБААТАР ХОТ
ХОЛБООНЫ
СУДЛЭЭ
9022050783
5061092 СБТ18969

Шалгуур үзүүлэлт 3

САНХҮҮГИЙН УДИРДЛАГЫН ГАЗРААС АЙМАГ, ДҮҮРГИЙН ГАЗРУУДАД ӨГӨХ ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

д/д	Газрын нэр	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД					Нийт оноо
		Худалдан авах ажиллагааны үр дүн	Авлагын насжилт, өглөгийн бууралт, тооцоо нийлэлтийн байдал	Тайлан мэдээний хугацаа, гаргалт, чанар, /нөат болон бусад/	Хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, тайлагналт	Өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт	
Авбал зохих оноо		**2**	**5**	**4**	**2**	**2**	**15**
1	Архангай						0
2	Баян-Өлгий						0
3	Баянхонгор						0
4	Булган						0
5	Говь-Алтай						0
6	Дорноговь						0
7	Дорнод						0
8	Дундговь						0
9	Завхан						0
10	Өвөрхангай						0
11	Өмнөговь						0
12	Сүхбаатар						0
13	Сэлэнгэ						0
14	Төв						0
15	Увс						0
16	Ховд						0
17	Хөвсгөл						0
18	Хэнтий						0
19	Дархан						0
20	Орхон						0
21	Багануур						0

ГАЗРЫН ЗАХИРАЛ Ж.БААСАНДОРЖ

Шалгуур үзүүлэлт 4

УЛААНБААТАР ХОТ
МЭДЭЭЛЭЛ ХЭВЛЭЛИЙН СТАНДАРТ ХХК
9022050763
5081092 СБТ18969

ЗАХИРГАА, ХҮНИЙ НӨӨЦИЙН ГАЗРААС АЙМАГ, ДҮҮРГИЙН ГАЗРУУДАД ӨГӨХ ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

д/д	Газрын нэр	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД			
		Судалгаа, мэдээллийг үнэн зөв хугацаанд нь ирүүлсэн байдал	Компанийн нөөцийн удирдлагын систем дээрх мэдээллийг тухай бүр шинэчилсэн байдал	Өгсөн үүрэг даалгаврын биелэлт	Нийт оноо
Авбал зохих оноо		**5**	**2**	**3**	**10**
1	Архангай				
2	Баян-Өлгий				
3	Баянхонгор				
4	Булган				
5	Говь-Алтай				
6	Дархан-Уул				
7	Дорноговь				
8	Дорнод				
9	Дундговь				
10	Завхан				
11	Орхон				
12	Өвөрхангай				
13	Өмнөговь				
14	Сүхбаатар				
15	Сэлэнгэ				
16	Төв				
17	Увс				
18	Ховд				
19	Хөвсгөл				
20	Хэнтий				
21	Багануур				

ГАЗРЫН ЗАХИРАЛ Б.БАДАМХОРОЛ

ЛААНБААТАР ХО
ХХК
9022050763
5081092 СБТ18969

ҮНДСЭН СҮЛЖЭЭНИЙ ГАЗРААС АЙМАГ, ДҮҮРГИЙН ГАЗРУУДАД ӨГӨХ ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

д/д	Газрын нэр	Сүлжээний чанарын үзүүлэлтүүд (20 оноо)	Гадаад байгууламжийн чанарын үзүүлэлтүүд (2 оноо)	Технологийн дагуу хийгдсэн ажил (14 оноо)	Тайлан, Face-3.0 програм, мэдээ өгөлт (4 оноо)	Нийт оноо 40 оноо
1.	Архангай					
2.	Баян-Өлгий					
3.	Баянхонгор					
4.	Булган					
5.	Говь-Алтай					
6.	Дархан-Уул					
7.	Дорноговь					
8.	Дорнод					
9.	Дундговь					
10.	Завхан					
11.	Орхон					
12.	Өвөрхангай					
13.	Өмнөговь					
14.	Сүхбаатар					
15.	Сэлэнгэ					
16.	Төв					
17.	Увс					
18.	Ховд					
19.	Хөвсгөл					
20.	Хэнтий					
21.	Багануур					

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР А.ДАМДИН

Шалгуур үзүүлэлт 7

УЛААНБААТАР ХОТ МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ 9022050763 5081092 СБТ18909

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА, ДОТООД ХЯНАЛТЫН ГАЗРААС АЙМАГ, ДҮҮРГИЙН ГАЗРУУДАД ӨГӨХ ҮНЭЛГЭЭ

д/д	Газар, нэгжийн нэр	Үнэлгээ өгөх чиглэл			Нийт оноо
		Эрсдэлийн удирдлагын чиглэлээр	ХАБЭА-н чиглэлээр	Дотоод хяналтын чиглэлээр	
Авбал зохиох оноо*		4	8	3	15
1.	Архангай				
2.	Баян-Өлгий				
3.	Баянхонгор				
4.	Булган				
5.	Говь-Алтай				
6.	Дархан-Уул				
7.	Дорноговь				
8.	Дорнод				
9.	Дундговь				
10.	Завхан				
11.	Орхон				
12.	Өвөрхангай				
13.	Өмнөговь				
14.	Сүхбаатар				
15.	Сэлэнгэ				
16.	Төв				
17.	Увс				
18.	Ховд				
19.	Хөвсгөл				
20.	Хэнтий				
21.	Багануур				

ГАЗРЫН ЗАХИРАЛ С.МӨНХЗОРИГ